

Portugal	Portuguese Public Finance Council (CFP)	4	Report on the Stability and Growth Programme, the Multiannual Framework of Budgetary Programming, The Proposed State Budget, Report on the Proposal for the State of Orcamento.
Slovak Republic	Council for Budget Responsibility (CBR)	2	Report on sustainability, report evaluating the implementation of the fiscal rules and fiscal transparency rules established in the law.
Slovenia	Slovenian Fiscal Council	4	Assessment of the Stability Programme, Assessment of the Draft Budgetary Plan, Execution of the Budget in the Previous Year and Report on Fiscal Council Operations.
Spain	Independent Authority of Fiscal Responsibility (AIReF)	10	Report on macroeconomic forecasts, Report on the methodology to calculate trend patterns of income and expenditure and the growth reference rate, Report on the draft Stability Programme, Reports on the analysis of budget implementation, public debt and debt-ceiling rule, Reports on the determination of individual objectives for autonomous regions, Report on economic-financial and re-balancing plans for the central administration and the autonomous regions, Report on the projects and main aspects of the budgets of public administrations, Report on the application of correction mechanisms foreseen in Organic Law 2/2012 of 27 April on Budgetary Stability and Financial Sustainability, Report on the occurrence of the exceptional circumstances referred to in Article 11.3 of Organic Law 2/2012, of 27 April, on Budgetary Stability and Financial Sustainability, and an annual opinion on the determination of the pension revaluation index.
Sweden	Swedish Fiscal Policy Council (FPC)	1	A report to government containing its analyses and assessments by 15 May each year.
UK	Office for Budget Responsibility (OBR)	4	Economic and fiscal forecasts and an assessment of the extent to which the fiscal mandate has been met (twice a year), Forecast Evaluation, Long Term Sustainability of Public Finances.
US	Congressional Budget Office (CBO)	1	One annual report including a discussion of national budget priorities and alternative ways of allocating budget spending among major programmes or functional categories.

Footnotes: In **Austria**, the PBO does not have enabling legislation. In **Latvia**, the Fiscal Discipline Council is mandated to provide two reports (on macroeconomic forecasts) through its legislation and two reports through its MoU with the Ministry of Finance.

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Г.Билгээ, И.Жаргалзаяабямба,
Ц.Элбэгзаяа*

АГУУЛГА

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТЫН ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

- НӨАТ-ын талаарх дэлхийн чиг хандлага
- НӨАТ-ын эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө

1. БНХАУ
2. ТАЙВАНЬ
3. ЕВРОПЫН ХОЛБОО
 - 3.1.Финланд
 - 3.2.Нидерланд
4. ОХУ

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

“Гадаадын зарим орны нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголтын талаарх зохицуулалт” судалгааны хүрээнд БНХАУ, Тайвань, ОХУ, Финланд, Нидерланд улс олон Европын холбооны нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний буцаан олголтын талаарх эрх зүйн зохицуулалтыг авч үзэв.

Нэмэгдсэн өртгийн албан татвар

Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) нь дэлхий даяар түргэн хугацаанд нэвтэрсэн бөгөөд одоогийн байдлаар дэлхийн 140 гаруй оронд хэрэгжиж байна. Дэлхийн улс орнуудын НӨАТ-ын дундаж хувь хэмжээг үзэхэд Азийн орнуудад бага буюу 12,3 хувьтай, Европын улсуудад харьцангуй өндөр буюу 20 хувьтай байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын хувьд НӨАТ-ын эрх зүйн орчинд өөрчлөлт оруулсан нийтлэг хандлага ажиглагдаж байх бөгөөд ингэхдээ НӨАТ-ын хувь хэмжээг өөрчлөн тогтоох, татварын цахим бүртгэлийн систем нэвтрүүлэх, татвар хураалтад хяналт тавих зэрэгт гол анхаарлаа хандуулсан байна.

Судалгаанд хамруулсан улс орнуудын хувьд НӨАТ-ын олон шатлалт хувилбарыг хэрэгжүүлж байна. Тухайлбал:

- БНХАУ-д -3-13 хувь;
- Тайваньд -0,1-25 хувь;
- ОХУ-д - 10-18 хувь;
- Финландад -10-24 хувь;
- Нидерландад -6-19 хувьтай байна.

НӨАТ-ын хөнгөлөлтийг эм, эмнэлгийн хэрэгсэл, тогтмол хэвлэл, ашгийн бус үйл ажиллагаанд нийтлэг байдлаар хэрэгжүүлж байна. БНХАУ-д жижиг бизнес эрхлэгчид, жижиг татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018-2020 онд 20000-30000 юаны борлуулалт бүхий татвар төлөгчдийг НӨАТ-аас чөлөөлж байгаа бол Тайваньд ХАА-н бөөний зах зээлд оролцогч ХАА-н бүтээгдэхүүнийг борлуулдаг жижиг ААН-ийн төлөөлөгчдөд 0.1 хувийн НӨАТ-ын татвар авч байна. Харин Финландад Аланд арлын бүс нутаг НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

НӨАТ-ын буцаан олголтын онцлог зохицуулалтууд

НӨАТ-ын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байх зорилгоор татвараас зайлсхийх явдлыг багасгах, далд эдийн засгийг хумих, татварын бааз суурийг нэмэгдүүлэх болон төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс **НӨАТ-ын буцаан олголтыг** улс орнууд хэрэглэж ирсэн.

Европын холбоо (ЕХ)-ны гишүүн улсуудад бүртгэлтэй татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтыг гишүүн аль ч орноос нэхэмжилж авах боломжтой болсон.

Финландад тухайн татварын жилд нэхэмжилж болох буцаан олголт ногдох борлуулалтын хэмжээ нь 400 евро, харин санхүүгийн сүүлийн улирлын тухайд нэхэмжилж болох буцаан олголт ногдох хэмжээ нь 50 еврогоос багагүй байхаар тогтоосон байна.

Нидерландад НӨАТ-ын буцаан олгох үйл явц нь татвар төлөгчөөс хамаарч байна. Тухайлбал, мэдүүлгийн маягтыг заавал бөглөж өгөх ба хугацаанаас нь хоцроосон тохиолдолд торгууль ногдуулна. Мөн татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголт авах хугацаагаа (сараар, улирлаар, жилээр) өөрөө тогтоох боломжтой зэрэг онцлог зохицуулалт байна.

ОХУ-д буцаан олголтыг татвар төлөгчийн дансанд татварыг буцаан олгохоос гадна татварын өр төлбөр (албан татварын дутуу төлөлт, анз, торгууль)-ийг төлөх, эсхүл ирээдүйд төлөгдөх татварт урьдчилж авах боломжийг хуулиар олгосон байна. Харин Тайваньд татварын илүү төлөлтийг ирээдүйд төлөгдөх татварт тооцон урьдчилж авах хуулийн зохицуулалт үйлчилж байна.

Эдийн засагт үзүүлж буй үр нөлөө

Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас харахад шууд бус татварын тогтолцоо болох НӨАТ нь татварын орлогын 25 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа нь шууд бус татварын тогтолцоонд илт давуу байр суурь эзэлж байна.

Судалгаанаас үзэхэд, **НӨАТ-ын буцаан олголт эдийн засагт дор дурдсан үр нөлөөг үзүүлж** байна. Үүнд:

- иргэдийн оролцоог идэвхжүүлэх замаар НӨАТ төлөгчдийг татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх чухал үр нөлөөтэй;
- татвараас зайлсхийх замаар нуугдан үлддэг байсан татварын орлогыг төсөвт төвлөрүүлэх;
- иж бүрэн бүртгэлийн тогтолцоог бий болгох замаар далд эдийн засгийг хумих (*эцсийн хэрэглэгч болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг урамшууллын системээр хөшүүрэгдэн татвар төлөгчид болон худалдаа үйлчилгээг бүртгэлжүүлэх*);
- татварын бааз суурийг тэлэх;
- татвар төлөгчийн худалдааны эргэлтийг сайжруулах, хариуцлагыг сайжруулах;
- албан бус секторт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг бүртгэлжүүлж, татварын тохирох хувь хэмжээ тогтоож болох эсэх бодлогын шийдвэр гаргах боломж бүрдэх (*учир нь албан бус сектор дахь худалдаа, үйлчилгээ эмзэг байдаг тул бага хэмжээний татварт ч мэдрэг байж, үйл ажиллагаа нь зогсох аюултай байдаг бөгөөд энэ салбарт төрийн уян хатан бодлого шаардагддаг*) зэрэг эерэг үр нөлөө үзүүлж байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН БУЦААН ОЛГОЛТЫН ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА


НӨАТ-ын талаарх дэлхийн чиг хандлага

НӨАТ нь орчин үед ашиглагдаж байгаа “эцсийн хэрэглээнд ногддог” хэрэглээний татварын 2 төрлийн нэг юм. Энэ татвар нь дэлхийн бусад улс орнуудад түгээмэл байсан үйлдвэрлэгчдийн худалдааны татвар (жишээ нь: Канад Улс), бөөний худалдааны татвар (Австрали, Шинэ Зеланд), худалдан авалтын татвар (Нидерланд), үйлдвэрлэлийн түвшний НӨАТ (БНХАУ) зэрэг шууд бус татварын 4 хувилбарыг орлон гарч ирсэн.⁹⁴

Шууд бус татваруудын боловсронгуй бус, үр ашиггүй байдал нь НӨАТ-ыг дэлхийн даяар түргэн хугацаанд нэвтрэхэд хүргэсэн. Ялангуяа, энэ үед татварын шинэчлэлүүд ихэвчлэн бизнес эрхлэлт, бизнесийн шийдвэр гаргахад сөрөг нөлөө үзүүлдэг гүйлгээний татваруудыг өөрчилж, хүчингүй болгоход чиглэгдэж байсан. Ийнхүү нээлттэй эдийн засаг бүхий дэлхийн улс орнууд бизнесийн ашиг болон эцсийн хэрэглэгчдэд буюу хувь хүмүүсийн хэрэглээнд шууд бус татвар ногдуулдаг тогтолцоо руу тасралтгүй шилжсээр байна.


⁹⁴ НӨАТ ба хэрэглээний татварын хувилбарууд. Р.Кревер. www.iltod.gov.mn

Зураг 1. НӨАТ-ыг нэвтрүүлсэн орнуудын статистик үзүүлэлт (1960-2000 он)⁹⁵



НӨАТ-ын хувь хэмжээний хувьд Азийн орнуудад дунджаар 12,3 хувь, Америк, Номхон далайн орнуудад дунджаар 13 хувь, Африкийн орнуудад 15 хувьтай байна. Харин Европын улсуудад дунджаар 20 хувьтай байгаа нь дэлхийн бусад оронтой харьцуулахад 5 хувиар өндөр байгааг дараах зургаас харьж болно.⁹⁶

Зураг 2. НӨАТ-ын хувь хэмжээ (бүс нутгаар, 2015 он)



Дэлхийн улс орнуудын чиг хандлагаас харахад шууд бус татварын тогтолцоо болох НӨАТ нь татварын орлогын 25 ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа нь шууд бус татварын тогтолцоонд илт давуу байр суурь эзэлж байна.

Судлаачдын үзэж байгаагаар НӨАТ нь гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтанд сөрөг нөлөөгүй бөгөөд экспортод 0 хувиар татвар ногдуулж, импортод үндсэн хувь хэмжээгээр ногдуулдаг зарчим нь гадаад худалдааны олон талт гэрээ, хэлэлцээр

⁹⁵ "The VAT: Its Causes and Consequences". M.Keen and B.Lockwood. International Monetary Fund. 2017. P.14.

⁹⁶ How Many Countries in the World Have a Value-Added Tax. Kyle Pomerleau. <https://taxfoundation.org>

Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын нийтлэг зарчимд нийцдэг байна.

НӨАТ-ын буцаан олголт нь татварын урамшуулал гэсэн ойлголтод хамаардаг тул ерөнхий утгаараа тухайн орны татварын тогтолцоо, тодорхой төрлийн татвар, тодорхой нэг буюу хэд хэдэн эдийн засгийн салбарын үр нөлөөг дээшлүүлэх, дотоодын болоод гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээ гэж үздэг байна. Эдийн засгийн онол, практик талаасаа НӨАТ нь өргөн хүрээнд хэрэглээнд үндэслэсэн, жижиглэн худалдааны үе шат бүрийг хамарч чадсан тохиолдолд НӨАТ-ын буцаан олголт нь үр дүнтэй байна гэж үздэг.

НӨАТ-ын буцаан олголтыг хэрэглэснээр бүртгэл, тайлагнал сайжирч, НӨАТ-ын орлогын хэмжээ дагаж нэмэгдэх, аж ахуйн нэгж (ААН)-ийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ сайжрах боломжтой байна. Судлаачдын үзэж байгаагаар онолын хувьд буцаан олголт нь НӨАТ-ын 30-50 хувьтай байх боломжтой гэж үзэж байна. Практикт буцаан олголтын хэмжээ Африкийн орнуудад хамгийн бага, орчин үеийн татварын систем хэрэгжүүлж байгаа, эсхүл эдийн засгийн хувьд хурдацтай байгаа орнуудын хувьд хамгийн өндөр байна.

Нэгэнт НӨАТ нь эцсийн хэрэглээнд татвар ногдуулах зорилготой тул тухайн тайлант хугацааны туршид худалдан авалтад төлсөн НӨАТ нь борлуулалтад ногдсон НӨАТ-аас давсан тохиолдолд түүнийг тухай бүр нь буцаан олгож байх ёстой. НӨАТ-ын илүү төлөлтийг цаг тухайд нь олгохгүй саатуулах нь бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны өртгийг нэмэгдүүлдэг.

Татварт төлсөн мөнгөө аливаа эх үүсвэрээр нөхөх шаардлагатай ба татвараа буцаан автлаа хөрөнгө зээлэх шаардлага ч гарч болно. НӨАТ-ын буцаан олголтыг саадгүй болгох үүднээс төсвийн зарцуулалтад зарим өөрчлөлт оруулах, хуурамч буцаан олголт олгохгүй байлгах нөхцөлийг бүрдүүлсэн үйл ажиллагааны болон хяналтын тогтолцоо чухал байдаг байна.

НӨАТ-ын эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй нөлөө⁹⁷

Юуны өмнө орчин үеийн эдийн засагч, эрдэмтэд нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг хүн төрөлхтний түүхэнд хамгийн өргөн тархсан төсвийн орлого бүрдүүлэх шилдэг татвар гэж үздэг байна. Гарал үүслийн хувьд 1954 онд Франц Улсад анх бараанд ногдуулан хэрэглээний татварын хэлбэрээр нэвтрүүлж эхэлсэн бөгөөд дэлхийн хоёрдугаар дайнаас хойш нийтдээ 140 гаруй улс уг татварыг нэвтрүүлсэн байна.

НӨАТ нь ихэнх улсад амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд төсвийн орлогын 18-40 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тодорхой шалтгаанаар цөөн тооны улс орнуудад энэ татвар амжилт олоогүй туршлага байдаг. Тухайлбал, Гана Улс татварын босгыг хэт бага тогтоосноос татвар төлөгчдийг хянах, татварын орлогыг бүрдүүлэх ажиллагааны зардал татварын орлогоосоо давж байсан нь тухайн үед НӨАТ-ын татварыг зогсооход хүрч байсан байна.

Харин Япон Улсад анх “хэрэглээний татвар” нэртэйгээр тогтоосон НӨАТ нь иргэдийн амьдралд хэт дарамт учруулснаар тус татварыг хүчингүй болгосон бөгөөд 1989 онд 3 хувьтайгаар дахин тогтоож, улмаар 1997 онд 5 хувьд хүргэж амжилттайгаар нэвтрүүлсэн байна.

Европын Холбооны хувьд НӨАТ нь Засгийн газрын орлогын (төсвийн) гол эх сурвалжуудын нэг юм. 2000 оноос хойш НӨАТ-ын орлого нь ДНБ-ний 0.6 хувиар өсч, улмаар төсвийн орлогын чухал эх үүсвэрүүдийн нэг болсон.

Өөрөөр хэлбэл, НӨАТ-ыг амжилттай хэрэгжүүлж буй 130 улсын туршлагаас нэгтгэн үзэхэд НӨАТ-ын **эдийн засагт үзүүлж буй гол үр нөлөө нь төсвийн орлогыг бүрдүүлэгч гол эх үүсвэрийн** нэг болж буй нийтлэг үр дүн харагдаж байна.

Гэвч НӨАТ-ын орлоготой холбоотойгоор тулгарч буй гол асуудлуудын нэг нь татвараас зайлсхийх явдал гэж “The influence of VAT on economic growth” судалгаанд онцолсон байна. Иймд татвараас нуусан мөнгөн хөрөнгийн эргэлт буюу далд эдийн

⁹⁷ Stefan Gabriel ets. “The influence of VAT on economic growth”. 2015.

засгийг ил болгох нь НӨАТ-ын орлогын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байхад ач холбогдолтой гэжээ.

Татвараас зайлсхийх хоёр төрлийн арга зам байх бөгөөд энэ нь:

- a) **Хууль тогтоомжийн хүрээнд татвараас зайлсхийх, эсхүл татварыг хүчингүй болгох (цуцлах)** – эдийн засгийн үр ашгийг хүртэхийн тулд хуулийн цоорхойг ашиглан татвараас зайлсхийх;
- b) **Хууль бусаар татвараас зайлсхийх** – хууль зөрчин татвараас зугтах замаар эдийн засгийн үр ашгийг өөртөө авах гэсэн хоёр төрлийн арга зам байна.

Иймд татвараас зайлсхийх явдлыг бууруулах, таслан зогсоохын тулд ЕХ нь **НӨАТ-ын онолын болон бодит орлогын зөрүүг тодорхойлох** замаар татвараас зайлсхийх явдалд дүн шинжилгээ хийж байна. ЕХ-нд Румын Улсын НӨАТ-ын зөрүү хамгийн өндөр буюу **48%**-ийн зөрүүтэй гарчээ. Энэ нь 2008 оны эдийн засгийн хямралаас үүдэлтэй хэрэглээ буурсантай холбоотойгоор **татвараас зайлсхийх явдал нэмэгдсэнээс үүссэн** гэж үзжээ⁹⁸. Өөрөөр хэлбэл, энэ нь Румын Улсын татвараас зайлсхийж буй далд эдийн засгийн үзүүлэлт юм.

Иймд НӨАТ-ын эдийн засагт үзүүлж буй үр нөлөөг бууруулахгүй байх зорилгоос үүдэн татвараас зайлсхийх явдлыг багасгах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс татварын урамшууллын нэг төрөл болох НӨАТ-ын буцаан олголтыг улс орнууд хэрэглэж ирсэн.

НӨАТ-ын буцаан олголтын эдийн засагт үзүүлж буй үр нөлөө нь:

- иргэдийн оролцоог идэвхжүүлэх замаар НӨАТ төлөгчдийг татвараас зайлсхийхээс урьдчилсан сэргийлэх чухал үр нөлөөтэй;
- татвараас зайлсхийх замаар нуугдан үлддэг байсан татварын орлогыг төсөвт төвлөрүүлэх;
- иж бүрэн бүртгэлийн тогтолцоог бий болгох замаар далд эдийн засгийг хумих (*эцсийн хэрэглэгч болон худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийг урамшууллын системээр хөшүүрэгдэн татвар төлөгчдийн болон, худалдаа үйлчилгээг хувийг бүртгэлжүүлэх*);
- татварын бааз суурийг тэлэх;
- татвар төлөгчийн худалдааны эргэлтийг сайжруулах, хариуцлагажуулах;
- албан бус секторт худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг бүртгэлжүүлж, татварын тохирох хувь хэмжээ тогтоож болох эсэх бодлогын шийдвэр гаргах боломж бүрдэх (*учир нь албан бус сектор дахь худалдаа, үйлчилгээ эмзэг байдаг тул бага хэмжээний татварт ч мэдрэг байж, үйл ажиллагаа нь зогсох аюултай байдаг тул энэ салбарт төрийн уян хатан бодлого шаардагддаг*) зэрэг эерэг үр нөлөө үзүүлж байна.

1. БНХАУ

1.1. НӨАТ-ын эрх зүйн зохицуулалт ба шинэчлэл

Хэдийгээр БНХАУ 1994 онд НӨАТ-ын хуулийг албан ёсоор баталсан хэдий ч, НӨАТ-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор нэлээд хэд хэдэн алхмуудыг шат дараалан хийж, улмаар 2016 онд НӨАТ-ыг шинэчлэх зорилгодоо хүрч, гүйлгээний татвараас НӨАТ-ын системд шилжсэн. БНХАУ-ын НӨАТ-ын тогтолцоо нь дэлхийд хамгийн нүсэр бөгөөд хамгийн хүчтэй “орлого цуглуулагч”-д тооцогддог ба улсын төсвийн орлогын хамгийн их хувийг эзэлдэг татвар юм.⁹⁹ Тухайлбал 2015 оны байдлаар татварын орлогын бүтцэд НӨАТ хамгийн их буюу 32 хувь, онцгой татвар 21 хувь, бизнесийн татвар 14 хувь, ААН-ийн орлогын албан татвар 8 хувь, хувь хүний орлогын албан татвар 6 хувь, бусад татварууд нийлээд 19 хувийг бүрдүүлж байна. Бүтцийн хувьд төдийлөн стандарт хэлбэртэй бус боловч хэрэгжилтийн түвшин нь жил ирэх тусам улам эрчимжсээр байна.

⁹⁸ Stefan Gabriel ets. “The influence of VAT on economic growth”. 2015

⁹⁹ “Нэмэгдсэн өртөгийн албан татварын буцаан олголт, гадаадын зарим орны туршлага”. УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. 2013 он

Хятадын шууд бус татварын систем олон жилийн хугацаанд салаалсан буюу бараа бүтээгдэхүүнд, бизнесийн үйлчилгээнд нэмүү өртгийн татвар ногдуулах байдлаар явж ирсэн. Хятад Улс 2012 оноос шууд бус татварын шинэчлэлийг хийж эхэлсэн бөгөөд өөрчлөлтийг салбар салбараар, муж мужаар хэрэгжүүлж явсаар 2016 оны 5 дугаар сарын 1 гэхэд шинэчлэлийг хийж дуусгасан байна. Одоо Хятадын НӨАТ нь тухайн татварыг хэрэглэдэг дэлхийн 140 гаруй улс орноос хамгийн өргөн хүрээг хамрах болсон бөгөөд санхүү, даатгал, үл хөдлөх хөрөнгө, барилга гээд санхүүгийн бүх салбарт, тухайлбал, хүүгийн орлого, үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх зэрэгт хэрэглэх болсон байна.

НӨАТ-ын шинэчлэл урт удаан хугацааны туршид хийгдсэн боловч, бизнес эрхлэгчид маш богино хугацаанд буюу зургаан долоо хоногт эдгээр өөрчлөлтүүдэд дасан зохицох, шинэ журмыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай болсон бөгөөд шинэчлэлийн сүүлийн үе шатууд нь бизнес эрхлэгчид болоод татварын албаныханд их хүч хөдөлмөр шаардсан, бэрхшээлтэй ажил байсан талаар дурджээ.

Улс орнуудын татварын байгууллагууд БНХАУ-ын НӨАТ-ын бодлогын өөрчлөлтөд анхаарлаа хандуулсаар байна. Учир нь БНХАУ-д хийгдэх тус өөрчлөлтүүд бусад орнуудын санхүүгийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгийн НӨАТ-ын хамгийн боломжит бодлогыг эргэн харахад хүргэж болзошгүй гэж үзэж байгаа ч зарим хүмүүс БНХАУ-д хийгдэх өөрчлөлт нь бодлогын болон техникийн талаас асуудал дагуулах эрсдэлтэй гэж үзэж байна.¹⁰⁰ Түүнчлэн БНХАУ-ын НӨАТ-ын систем нь бусад орнуудад байдаггүй, уламжлалт бус шинж чанаруудыг мөн агуулж байна.

Сүүлийн жилүүдэд БНХАУ-ын Засгийн газар зорилгодоо тулгуурлан үйлдвэрлэлийн эдийн засгаас илүү үйлчилгээний эдийн засагт шилжихийг зорьж байгаа бөгөөд НӨАТ-ын шинэчлэлийг амжилттай шилжих нэг арга зам гэж тодорхойлсон байна. Гэсэн хэдий ч Хятадын НӨАТ-ын систем нь хэт нүсэр, хамгийн төвөгтэй улс орны нэг гэж тооцогддог бөгөөд 2016 онд шинэчлэлийг бүрэн хийж дууссан ч НӨАТ-ын системийн төвөгтэй байдал нь хэвээр байх төлөвтэй байна гэж ажиглагчид үзэж байна.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Хятадын эдийн засгийн хурдацтай өсөлт, зах зээлийн даяаршил нь Хятад улс дотоодын болон олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц, хэвээр байхын тулд шууд бус татварын системээ орчин үеийн болгож шинэчлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Одоо Хятад Улс нь Хонконг, Макаогоос бусад газарт буюу эх газарт нэмэгдсэн өртгийн болон хэрэглээний гэсэн 2 төрлийн шууд бус татварыг хэрэглэж байна. НӨАТ-ыг экспорт, импортын бүх худалдаа, бараа, ажил үйлчилгээнд хэрэглэдэг. Хэрэглээний татварыг үйлдвэрлэл, импорт болон тансаг хэрэглээний 14 нэр төрлийн барааны худалдаанд хэрэглэдэг. НӨАТ-ын ердийн хэмжээ 17 хувь байна. Ердийн хэмжээг ихэнх төрлийн барааны импорт, худалдаа, засварын үйлчилгээ боловсруулах үйлчилгээ, хөдлөх хөрөнгийн лизинг зэрэгт хэрэглэдэг. НӨАТ-ын бууруулсан хэмжээг бусад салбар, бараа үйлчилгээнд хэрэглэж байна. Тухайлбал:

3 хувь	500000 - 5000000 юаны борлуулалт бүхий тогтвортой бус жижиг бизнес, ажил үйлчилгээ эрхлэгчдэд;
5 хувь	тодорхой төрлийн үл хөдлөх хөрөнгийн худалдаанд;
6 хувь	судалгаа үйлчилгээ, техник, мэдээллийн технологи, соёл, санхүү, даатгал, зөвлөх, зурагт радио, спорт, боловсрол, эрүүл мэнд зэрэг орчин үеийн ажил үйлчилгээнд;
11 хувь	тээвэр, харилцаа холбоо, үл хөдлөх болон барилга, шуудангийн үйлчилгээнд;
13 хувь	ном, сонин, сэтгүүл, үр тариа, тос, газ, халаалт, хөргөлтийн ажил үйлчилгээ, бараанд.

Хөдөө аж ахуй (ХАА)-н болон жирэмслэлтээс хамгаалах эм, багаж хэрэгсэл, эртний ном зохиолтой холбогдох бараа, ажил үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлдөг байна.

Гадаадын ААН-үүд НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх шаардлагагүй бөгөөд худалдааны

¹⁰⁰ www.ibfd.org/sites/ibfd.org/files/content/pdf/ivm_2017_02_cn_1_PPV_AugNewsletter.pdf

бүсүүдэд үйл ажиллагаа явуулна.

Дотоодын ААН-үүд борлуулалтын дүнгээс хамааран ердийн болон жижиг татвар төлөгчөөр бүртгүүлдэг байна. Жилийн борлуулалт 800000 юанаас хэтрэхгүй, эсхүл бараа үйлдвэрлэх, засвар үйлчилгээ, боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийн борлуулалт нь 500000 юаниас хэтрэхгүй ААН-ийг жижиг татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Хятадын НӨАТ нь Европын орнуудын НӨАТ-аас ялгаатай нь зөвхөн бараанд, цөөн тооны үйлчилгээнд хамаардаг байна. Энэ нь зөвхөн үйлдвэрлэлийн болон борлуулалтын үе шат бүрт нэмүү өртөг нэмдэггүй учир нь төвийг сахисан явдал биш юм. Хэдийгээр Хятадын НӨАТ болон буцаан олголт нь үр өгөөжөө өсгөж, эдийн засгийн хөгжилд түлхэц үзүүлж байгаа боловч цаана нь олон бодлогын болоод үйл ажиллагааны асуудал байсаар байна гэжээ.

1.2.НӨАТ-ын буцаан олголт

ОУВС-ын тооцоолсноор буцаан олголт нь НӨАТ-ын нийт орлогын 30 хувиас хэтрэхгүй байх ёстой бөгөөд буцаан олголтын тогтолцоо нь НӨАТ-ыг хэрэгжүүлэх гол тулгуур нь гэж тооцогддог байна.

Хятадын НӨАТ-ын буцаан олголттой холбоотой асуудлуудыг НӨАТ-ын хууль, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Сангийн яамнаас тухай бүр гаргасан шийдвэр, хэрэгжүүлэх журмуудаар зохицуулж байна. Энэ талаар Хятадын татварын хууль тогтоомж болон олон улсын татварын хөтөч цахим хаягнаас дэлгэрэнгүй үзэх боломжтой.¹⁰¹

НӨАТ-ыг буцаан олгох тал дээр Хятадын татварын алба ихээхэн хатуу байр сууринаас ханддаг бөгөөд үйл ажиллагааны төрөл, экспортын бүтээгдэхүүний ангиллаас хамааран буцаан олгох хувь хэмжээг тусгай жагсаалтаар ялгавартай тогтоодог байна.¹⁰² Хэдийгээр 17 хувийн татвар төлсөн байсан ч 5-17 хувиар тооцож буцаан олголт олгодог байна. НӨАТ-ын буцаан олголт авах бүтээгдэхүүний жагсаалт жил ирэх тусам багасаж байгааг тэмдэглэжээ.

Санхүү татварын асуудал эрхэлсэн яамнаас 2017 оны 4 дүгээр сард баталсан журмаар буюу түүний хавсралтад тодорхойлон заасан тодорхой бараа үйлчилгээнд 11 хувь байхаар заасан байна. 10000 юанаас дээш буцаан олголтыг банк, бусад буцаан олголтыг тусдаа үйлчилгээний цэгүүдээр дамжуулан олгодог байна. Үүнээс 2 хувийг үйлчилгээний хөлсөнд суутган авч үлддэг байна.¹⁰³

Жижиг бизнес эрхлэгчид болон жижиг татвар төлөгчдөд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд сарын 20000-30000 юаны борлуулалт бүхий татвар төлөгчдийг НӨАТ-аас чөлөөлөх шийдвэрийг санхүү татварын асуудал эрхэлсэн яамнаас гаргасан байна.

2016 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс дипломат төлөөлөгчийн болон олон улсын байгууллагын албан хаагч, ажилчдад олгох НӨАТ-ын буцаан олголтод дараах зүйлс хамаарахгүй байхаар шийдвэрлэсэн байна.

- хувийн болон албаны хэрэгцээндээ зориулан худалдан авсан өдөр тутмын ажил, амьдралд шаардлагатайгаас бусад эд зүйлс;
- нэг удаагийн баримтаар 800 юанаас доош үнэтэй бараа, 300 юанаас доош үнэ бүхий үйлчилгээ;
- НӨАТ-аас чөлөөлөгдсөн бараа үйлчилгээ.

Олон улсын болон дипломат төлөөлөгчийн газрууд нь буцаан олголтыг авахаас өмнө Гадаад хэргийн ямаар дамжуулан буцаан олголт авах эрх бүхий албан хаагчдын нэрс, холбогдох дансны дугаар зэрэг мэдээллийг өгөх шаардлагатай байдаг байна. Буцаан олголтын хүсэлтийг холбогдох цахим хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр гаргана.

2016 онд Бүгд Найрамдах Польш Улстай агаарын тээврийн үйлчилгээнд НӨАТ болон

¹⁰¹ <http://tax.mofcom.gov.cn/tax/taxfront/en/list.jsp?c=30105>

¹⁰² Борлуулалтын татвар ба НӨАТ-ын харьцуулсан судалгаа, О.Цогт

¹⁰³ <http://tax.mofcom.gov.cn/>

холбогдох татварыг харилцан ногдуулахгүй байхаар шийдвэрлэсэн.

2017 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын ажилтнуудын хувийн хэрэгцээндээ худалдан авсан автомашин, орон сууц түрээслэхээс бусад бараа үйлчилгээд олгох НӨАТ буцаан олголтын хэмжээ нэг жилд нэг хүнд 180000 юанаас хэтрэхгүй байхаар холбогдох яамнаас шийдвэр гаргасан байна.

2. ТАЙВАНЬ

2.1. НӨАТ

НӨАТ-ын хэмжээний хувьд Тайваньд НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус гэсэн 2 системтэйгээр татвар ногдуулдаг. Үүнийг НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар “Бизнесийн татварын хувь хэмжээ 5 хувиас доошгүй, 10 хувиас дээшгүй байхаар заажээ. НӨАТ төлөгчийн татварын хамрах хүрээ нь НӨАТ төлдөг бүх ААН-үүд болон НӨАТ төлөгчийн бус ААН-үүдийг хамардаг. НӨАТ төлөгч нь бараа ажил, үйлчилгээний үйлдвэрлэлт, хуваарилалтыг нэмэгдсэн өртгийн дагуу ногдуулдаг. НӨАТ төлөгчийн татварын хувь хэмжээ нь 5 хувьтай байна. Харин НӨАТ төлөгчийн бус татварын хамрах хүрээ нь НӨАТ төлөгчийн бус санхүүгийн байгууллага, ресторан, жижиг компаниудын бизнесийн мөнгөний баримтыг бүрдүүлэх үндсэн дээр хийдэг. НӨАТ төлөгчийн бус нь нэмэлт худалдан авалтын зардлыг төлөхгүй. НӨАТ төлөгчийн бус татварын хэмжээг 0,1-25 хувиар ногдуулна.

Хувь хэмжээ	НӨАТ төлөгч бус
25 хувь	Салон ба цайны өрөө, кофе шоп, баар, үйлчлүүлэгчдийг зугаацуулагч, харилцагчийг хүлээн авах
15 хувь	Шөнийн клуб болон ресторан, үзвэр үзүүлэх үзүүлбэр
үндсэн: 2 хувь бусад: 5 хувь	Банк болон даатгал, хөрөнгө оруулалтын итгэмжлэл, үнэт цаасны байгууллага, фючерс, арилжааны байгууллагууд, ломбардууд
1 хувь	Даатгалын байгууллага, давхар даатгалын хураамж
1 хувь	СЯ-наас чөлөөлөгдсөн жижиг ААН-үүд, массажны үйл ажиллагаа эрхлэх харааны бэрхшээлтэй иргэд
0.1 хувь	ХАА-н бөөний зах зээлд оролцогч ХАА-н бүтээгдэхүүнийг борлуулдаг жижиг ААН-ийн төлөөлөгчид

2.2. НӨАТ-ын буцаан олголт

Тайваний Үндэсний татварын алба (УТА), Сангийн Яам нь БНХАУ-д зорчиж байгаа гадаадын жуулчид, 183 хоногоос дээш хугацаагаар оршин сууж буй гадаадын иргэнд НӨАТ-ын буцаан олголт олгох зорилгоор Татварын буцаан олголтын цэгийг ажиллуулдаг бөгөөд нэг өдөрт 2,000NT\$¹⁰⁴ тайвань доллараар ба түүнээс дээш хэмжээтэй худалдан авалт хийсэн бол 90 хоногийн дотор НӨАТ буцаан олголт авах хүсэлтийг гаргах эрхтэй. НӨАТ-ын буцаан олголтыг олгохын тулд жуулчдад дараах гурван аргын аль нэгийг сонгож болно. Үүнд:

1) Онгоцны буудал, далайн боомтын терминал дээр татвар буцаан олгох үйлчилгээг сонгохдоо: Жуулчид нисэх онгоцны буудал, далайн боомтоос өөрийн татварыг буцаан олгогч “НӨАТ-ын буцаан олголтын машин” (e-VAT, VAT refund machine)-аар үйлчлүүлэх буюу үйлчилгээний оператороор үйлчлүүлэн НӨАТ-ын буцаан олголтыг авч болно.

2) Жуулчид доорх нөхцөлийг хангасан тохиолдолд Татварын буцаан олголтын цэгээс НӨАТ буцаан олголтын үйлчилгээг авна. Үүнд:

а. худалдан авсан барааны дүн нь тухайн дэлгүүрээс нэг өдрийн 24,000NT\$ ба түүнээс бага;

б. нийт худалдан авалтын хэмжээ 120,000NT \$-с хэтрэхгүй байх;

¹⁰⁴ мөнгөн нэгжийн 2018.04.18-ны өдрийн ханш 1 USD= 29,3675 TWD буюу NT\$ тэнцэнэ.

в. нийт худалдан авалтын хэмжээ нь хуанлийн жилдээ 240,000NT\$ хэтрэхгүй байна.

3) Жуулчид үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн тохиолдолд НӨАТ-ын буцаан олголтын төлбөрийг буцаан авахдаа кредит карттай байх ёстой, (худалдан авалтын дүнгийн 7 хувьтай тэнцэх хэмжээний урьдчилсан төлбөр) зарлагадсан өдрөөс 20 хоногийн дотор буцаан олголтыг авна. Жуулчид онгоцны буудал болон хөлөг онгоц, далайн боомтод НӨАТ-ын цахим машинаар үйлчлүүлэх боломжтой. Дээрх журмуудыг дагаж мөрдөөгүй тохиолдолд буцаан олголтыг өгөх боломжгүй болно¹⁰⁵.

НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай хуулийн 35 дугаар зүйлд “Энэ хуульд зааснаар, ААН-ийн борлуулалтаас үл хамааран татварын буцаан олголтыг 2 дугаар сард төлсөн татварын хэмжээний дагуу олгоно. Татварын албанд дараа сарын 15-ны өдрийн дотор татвар буцаан олголтын холбогдох бичиг баримтыг бүрдүүлж өгнө. Бизнесийн татварын төлбөл зохих дүнг Засгийн газрын сангаас урьдчилан төлнө. Татвар төлсөн баримтыг татварын тайланд хавсаргана. Энэ хуулийн 7 дугаар зүйлд дурдсан бизнесийн татварын хувийг тэглэх заалтыг хангасан ААН-ийн хувьд сарын борлуулалтын дүнг дараа сарын 15-ны өдрийн дотор татвар төлөх эрх бүхий байгууллагад хандана. Сар бүр батлагдсан татварын буцаан олголтыг ААН-ийн мэдүүлгийн хугацааг нэг жилийн дотор өөрчлөх эрхгүй. Өмнөх 2 мөрөнд дурдсанаар ААН-үүд, төлбөрийн нэхэмжлэлийг ашиглаж байгаа бол ашиглагдаж буй нэгдсэн нэхэмжлэхийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсаргана” гэж заажээ.

Мөн хуулийн 38 дугаар зүйлд зааснаар БНХАУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй ААН, орон нутгийн бусад байгууллагууд татварын буцаан олголт, татвар төлөх, илүү төлөлтийн асуудлыг төв байгууллага болон орон нутгийн татварын албанд хүсэлтээ гарган шийдвэрлүүлнэ.

Энэхүү хуулийн 39 дүгээр зүйлд дурдсанаар доорх нөхцөлд ААН-ийн нэхэмжилсэн бизнесийн илүү төлсөн татварын дүнг эрх бүхий татварын алба баталгаажуулсны дараа татварыг буцаан олгоно. Үүнд:

1. бизнесийн татвараас илүү төлсөн төлбөр нь 7 дугаар зүйлд заасны дагуу 0 хувьтай татварт ногдуулсан бараа, үйлчилгээг хамаарна;

2. бизнесийн татвараас илүү төлсөн төлбөр нь худалдан авсан үл хөдлөх хөрөнгө хамаарна;

3. бизнесийн татвараас илүү төлсөн төлбөр нь бизнесийг нэгтгэх, бизнес шилжүүлэх, татан буулгах, хүчингүй болгохтой холбоотойгоор бүртгэлийг цуцалсан өргөдөл гаргасан ААН-ийг хамруулжээ.

Дээр дурдсанаас бусад нөхцөл байдлаас үүссэн татварын илүү төлөлтийг ирээдүйд төлөгдөх татварт тооцон урьдчилж авч болно. Тусгай нөхцөлтэй ААН-үүд татварын хөнгөлөлтийг хүлээн авах хүсэлтийг Сангийн яамд татварын хөнгөлөлт эдлэх өргөдлийг гаргаж болно” гэж тусгажээ.

2.3.Хууль эрх зүйн орчин

Тайвань нь НӨАТ-ыг дараах хууль тогтоомжийн хүрээнд зохицуулдаг байна. Үүнд:

1) Тайваний НӨАТ төлөгч болон НӨАТ төлөгч бус бизнесийн тухай хуулийн 1 дүгээр бүлэгт “Импортын бүтээгдэхүүн, БНХАУ-ын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээнд НӨАТ-ыг ногдуулахад энэ хууль үйлчилнэ” гэж заажээ. Энэхүү хуульд бизнесийн татвар төлөгч, шилжүүлэг, татварын хувь хэмжээ, бизнесийн татвараас чөлөөлөх, татвар болон тусгай татварын тооцоолол, татвар бүрдүүлэх журам, бүртгэлийн маягт, татварын буцаан олголт, татвар төлөлтөнд тавих хяналт, татвар төлөгдөөгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлага зэрэг асуудлуудыг хамруулжээ.

2) НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай хуулийг дагаж мөрдөх журамд¹⁰⁶ нь НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай

¹⁰⁵ Сангийн яам <https://www.mof.gov.tw/Eng/Detail/Index?nodeid=319&pid=71590>

¹⁰⁶ Enforcement Rules of Value-added and Non Value - added Business Tax Act. 1931.06.31-ний өдөр батлагдсан. Энэ хууль нь 7 бүлэг, 60 зүйлтэй. Сангийн яамны Е татварын цахим хуудас.

хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулагдана.

3) Тайваньд мөрдөгдөж буй “НӨАТ-ын буцаан олголтыг авах гадаадын зорчигчдын худалдан авсан бараанд буцаан олголт хийх, НӨАТ-ын талаарх дүрэм, журмыг”¹⁰⁷ боловсруулсан.

4) БНХАУ-ын нутаг дэвсгэрт түр зуурын бизнес эрхэлдэг холбоод, эсвэл гадаадын аж ахуйн нэгж, нийгэмлэг, байгууллагаас худалдаж авсан НӨАТ-ын бараа, ажил үйлчилгээ үзүүлэхэд НӨАТ-ын буцаан олголтонд хяналт тавих журмыг¹⁰⁸ 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

5) Гадаадын зорчигчдын худалдан авах барааны НӨАТ-ын буцаан олголтыг зохицуулах журамд¹⁰⁹ гадаадын зорчигчдын БНХАУ-ын нутаг дэвсгэрт 183 хоногоос багагүй хугацаанд аялахдаа зөвшөөрөгдсөн дэлгүүрээс (TRS) худалдан авалт хийж, НӨАТ бүртгүүлж, шаардлага хангасан тохиолдолд НӨАТ-ын буцаан олголтод хамрагдах боломжтой.

6) Татвар бүрдүүлэх тухай хуулиар¹¹⁰ татвар бүрдүүлэлтийг зохицуулдаг байна.

7) Татварын бүртгэл хөтлөх журмын¹¹¹ дагуу ААН-үүд татварын бүртгэлийг явуулна.

8) Мөнгөн шагнал нэхэмжлэх журам¹¹² нь НӨАТ төлөгчийн болон НӨАТ төлөгчийн бус бизнесийн тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу сугалааны мөнгөн урамшууллыг олгох асуудлыг зохицуулсан байна.

3.ЕВРОПЫН ХОЛБООНЫ УЛСУУД

НӨАТ-ын буцаан олголтыг илүү нарийвчлан зохицуулж, журамлах зорилготой Европын Холбооны НӨАТ-ын буцаан олголтын журам 2009 онд батлагдаж, улмаар 2010 оноос мөрдөгдөж эхэлжээ.

Үүний үр дүнд ЕХ-ны бизнес эрхлэгч, татвар төлөгч нар нь оршин суугаа буюу байгуулагдсан орныхоо татварын байгууллагын цахим хуудсаар дамжуулан НӨАТ-ын буцаан олголтын нэхэмжлэл гаргаж, буцаан олголтыг авах боломжтой болсон байна. Хуучин мөрдөгдөж байсан зохицуулалтаар бол НӨАТ-ын буцаан олголтыг авахдаа заавал бичгийн хэлбэрээр, НӨАТ-ын буцаан олголтыг өгөх улсаар дамжуулан нэхэмжлэл гаргадаг байсан байна.

Харин буцаан олголтын шинэ батлагдсан журмаар нэхэмжлэл гаргах үйл явц, нэхэмжлэл гаргах хугацаа, хүлээн авах журам зэргийг ихэд хялбарчилж өгсөн байна. ЕХ-ны гишүүн улсуудад бүртгэлтэй татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтыг гишүүн орнуудаас нэхэмжилж авах боломжтой болсон бөгөөд одоо ЕХ-ны улсууд нь энэхүү журамд заасан зохицуулалтад үндэслэн НӨАТ-ын буцаан олголтыг хэрэгжүүлж байна. ЕХ-ны улс орнууд НӨАТ-ын буцаан олголтод хамрагдахгүй бараа, үйлчилгээг улс орон бүр харилцан адилгүй өөр өөр тогтоосон байна.

Судлаачдын үзэж байгаагаар НӨАТ-ын илүү төлөлтийг буцаан олгодог татвараас зайлсхийх хандлага сүүлийн жилүүдэд илүү гарч байна гэж үзэж байна. Экспортын

¹⁰⁷ Regulations Regarding the Claiming of VAT refund by Foreign Passengers Purchasing Goods Eligible for VAT refund. Сангийн яам, Зам тээвэр, Харилцаа холбооны яамны хамтарсан 2016 оны 1 дүгээр сарын 1-ний тушаалаар баталгаажсан. Энэ журам нь 6 бүлэг, 54 зүйлтэй. цахим хаяг: <http://admin.taiwan.net.tw/upload/law/20150907/3db03f8f-b961-4da1-8fc5-8fd71579321a.pdf>

¹⁰⁸ The Regulations Governing the Claiming of VAT Refunds for Goods and Services Eligible for VAT Purchased by Foreign Enterprises, Institutions, Organizations, or Associations Engaging in Exhibitions or Temporary Business Activities within the Territory of the Republic of China. БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас: http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll_print.aspx?PCode=G0340126

¹⁰⁹ Regulations Governing VAT refund Claims by Foreign Travelers Purchasing Goods Eligible for VAT refund. 2016.12.30-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас: http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll_print.aspx?PCode=K0110023

¹¹⁰ Tax Collection Act. 2013.05.29-ны өдөр Ерөнхийлөгчийн зарлигаар нэмэлт, өөрчлөлт орсон. Сангийн яам <http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=75>

¹¹¹ Regulations Governing Taxation Registration. 2017.03.29-ны өдөр нэмэлт, өөрчлөлт орсон. Энэ журам нь 4 бүлэг, 20 зүйлтэй. Сангийн Яам: <http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=250>

¹¹² Inform Invoice Award Regulations. 2016.12.15-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан.

бараанд 0 хувиар татвар ногдуулдгаас, ялангуяа ЕХ-ны улсуудад төрөл бүрийн татвараас зугтах арга техникүүд бий болж хэдэн сая еврогийн хуурамч буцаан олголтууд хийгдэж байна. Хэдийгээр ихэнх улс орнууд НӨАТ-ын буцаан олголтыг олгохоос өмнө маш нарийн чанд хяналт хийж, хуурамч нэхэмжлэлийг илрүүлэх тогтолцоог бий болгож чадсан ч татвараас зайлсхийх аргуудад өртөмтгий хэвээр байна.

3.1. Финланд

1993 онд батлагдсан Финландын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулиар бизнес эрхлэх хүрээнд дэх бараа, үйлчилгээ, импортын бараа бүтээгдэхүүнд НӨАТ ногдуулж, улсад төлөх үүрэгтэй гэж заажээ. Бизнес эрхлэх хүрээ гэдэгт цалин хөлсийг хамруулахгүй гэж заасан байна. Татвар төлөгч гэдэгт бараа үйлчилгээг зарж, борлуулж буй этгээдийг нэрлэсэн байна. Тус улсын хуулиар үл хөдлөх хөрөнгө, түүнтэй холбогдох эрх, үл хөдлөх хөрөнгө эзэмшиж, ашиглахтай холбоотой цахилгаан, ус зэрэг хэрэглээнд НӨАТ ногдуулахгүй байхаар заасан байна.

Финландад НӨАТ-ын стандарт хэмжээ 24 хувь байх бөгөөд 14 болон 10 хувийн бууруулсан НӨАТ байна. “Европын орнуудын НӨАТ-ын буцаан олголтын хөтөч 2017”-д дурдсанаар Финландын НӨАТ-ын хэмжээ байнга нэмэгдэж ирсэн бөгөөд 2013 онд дээрх хэмжээнд хүрч түүнээс хойш өөрчлөлт ороогүй байна.

Хүнсний бараа бүтээгдэхүүн, ХАА-н бараа үйлчилгээнд 14 хувийн НӨАТ, эмийн бүтээгдэхүүн, тээвэр, ном сонин, соёлын үйлчилгээ, зугаа цэнгэл, ресторан, спортын бараа үйлчилгээнд 10 хувь зэргээр багасгасан НӨАТ ногдох бараа, ажил үйлчилгээг жагсаалтаар дэлгэрэнгүй тогтоож өгсөн байна. Ашгийн төлөө бус байгууллагуудын хэвлэх үйлчилгээ, нийтийн болон олон улсын тээврийн үйлчилгээ зэрэгт 0 хувийн татвар ногдуулдаг байна.¹¹³ Финландад Аланд арлын бүс нутаг НӨАТ-аас чөлөөлөгддөг байна.

Финландад байгуулагдсан ААН буцаан олголтыг бусад гишүүн улсуудаас нэхэмжлэхдээ татварын цахим хуудсаар дамжуулан цахим хэлбэрээр гаргадаг. Хүсэлтээ өөрөө, эсхүл төлөөлөгчөөрөө дамжуулан гаргана. Нэхэмжлэлд НӨАТ буцаан олголтыг нэхэмжлэгчийн болон нэхэмжлэл, холбогдох гүйлгээний баримт нэхэмжлэх зэргийн мэдээллийг тусгаж, баримтыг хавсаргадаг байна. Харин ЕХ-ны бусад улсуудад байгуулагдсан ААН-үүд Финландаас буцаан олголт авахад дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Финланд Улсад үүсгэн байгуулагдаагүй бөгөөд тус улсад байнгын үйл ажиллагаа явуулдаггүй буюу байрладаггүй бол;
- тухайн гүйлгээ, худалдаа Финландад хийгдсэн бөгөөд хуулиар тус худалдааг НӨАТ бүртгэлд бүртгүүлэхээр, гадаадын компанид НӨАТ-ын буцаан олголт өгөхөөр заасан бол;
- тухайн компани Финланд Улсад ажил үйлчилгээ, бизнес эрхэлдэггүй бол;
- тээврийн болон бусад туслах үйлчилгээнээс чөлөөлөгдсөн борлуулалт.

Дараах тохиолдолд НӨАТ буцаан олголт олгогдохгүй¹¹⁴:

- татвар ногдох этгээд, түүний албан хаагчдын оршин суух буюу хэрэглэж, ашиглаж буй амьдрах, асаргаа сувилгаа, амралтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, тус зорилгоор хэрэглэж буй, эсхүл түүнтэй холбогдох бараа, үйлчилгээ;
- татвар ногдох этгээд, түүний албан хаагчдын оршин суугаа газар болон ажлын хооронд явах тээвэрлэлттэй холбогдох бараа, үйлчилгээ;
- бизнесийн зугаа цэнгэлтэй холбогдох бараа, үйлчилгээ албан ажлын хүрээний бэлэг, рестораны үйлчилгээ зэрэг;
- амралтын болон спортын зориулалт бүхий мотоцикл, суудлын автомашин, завь, онгоц 1550 кг-аас хэтрэхгүй өөрийн жинтэй нисэх онгоц, албан ажлын зориулалт бүхий автомашин, жолооны курс, нийтийн тээврийн зориулалт бүхий тээврийн хэрэгслийн худалдаа, түрээсийн үйлчилгээнд буцаан олголтыг зөвшөөрнө;

¹¹³ European VAT refund guide 2017, <https://www2.deloitte.com/content/dam/Deloitte/global/Documents/Tax/dttl-tax-european-vat-refund-guide.pdf>

¹¹⁴ European VAT refund guide 2017, page 89.

- татвар ногдох этгээд, түүний албан хаагчдын зугаа цэнгэлийн зорилгоор хэрэглэж буй хувийн хэрэгцээний бараа, үйлчилгээ;
- гадаадын аялал жуулчлалын компанийн нэрээр хийгдэж буй бараа, үйлчилгээ;
- санамсаргүйгээр суутгагдсан НӨАТ үл ногдох бараа үйлчилгээ.

“Европын орнуудын НӨАТ-ын буцаан олголтын хөтөч 2017”-д тэмдэглэснээр тухайн татварын жилд нэхэмжилж болох буцаан олголт ногдох борлуулалтын хэмжээ нь 400 евро, харин санхүүгийн сүүлийн улирлын тухайд нэхэмжилж болох буцаан олголт ногдох хэмжээ нь 50 еврогоос багагүй байх шаардлагатай байна.

НӨАТ-ын буцаан олголтын нэхэмжлэл нь нэг жил дотор, түүн дотроо 3 сараас доошгүй хугацааг хамарсан байх бөгөөд холбогдох төлбөрийн нэхэмжлэлийн дагуу төлбөрийг төлсөн бараа үйлчилгээг хүлээн авсан байх ёстой.

Импортын барааны тухайд барааг гааль дээр мэдүүлсэн үеэс эхлэн нэхэмжлэх эрх үүснэ.

Татварын байгууллага буцаан олголтын нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш 4 сарын дотор шийдвэрлэнэ. Шийдвэрийг шуудан болон цахимаар илгээнэ. Нэмэлт материал шаардлагатай бол энэ тухай мөн шуудангаар мэдэгдэх бөгөөд нэхэмжлэл гаргагч нь 1 сарын дотор холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлсэн байна.

Энэ тохиолдолд шийдвэрлэх хугацаа 6, эсхүл 8 сар болж сунгагдана. Олгох шийдвэр гарсан бол татварын байгууллага ажлын 10 хоногийн дотор холбогдох банкинд буцаан олголтыг шилжүүлнэ.

ЕХ-оос бусад улсын банкинд шилжүүлгийг хийхгүй. Татварын байгууллага буцаан олголтын хугацааг хэтрүүлсэн бол холбогдох хүүг төлөх үүрэгтэй. Олгох үндэслэлгүй гэж үзсэн бол нэхэмжлэгчид энэ талаараа мэдэгдэх ба нэхэмжлэгч нь энэ талаар Татварын давж заалдах хороонд гомдлоо гаргаж болно.

Гомдолд гомдол гаргагчийн нэр, татвар төлөгчийн дугаар, гаргасан шийдвэрийн үндэслэл, маргааны үндэслэл, холбогдох баримт сэлтийг хавсарган 60 хоногийн дотор гомдол гаргаж болно. Гомдлыг холбогдох материал дутуу буюу эргэлзээтэй гэсэн үндэслэлээр бүхэлд нь хэрэгсэхгүй болгохыг хориглох бөгөөд тухайн эргэлзээтэй гэж үзсэнээс бусад буцаан олголтын асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй байна. Татварын зөвлөл нь буцаан олголтыг нэмэгдүүлэх буюу багасган тогтоож болох бөгөөд шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор буцаан олголтыг олгох үүрэгтэй байдаг байна.

3.2.Нидерланд

Нидерландын гол татваруудын нэг болох НӨАТ нь 1968 онд батлагдсан НӨАТ-ын тухай хуулиар¹¹⁵ зохицуулагдана.

НӨАТ-ын стандарт хувь хэмжээ 19 хувь байна. 6 хувийн бууруулсан хувь хэмжээ нь импорт болон Хамтын нийгэмлэгийн дотор бараа, үйлчилгээ авах үйл ажиллагаа болно. Буруулсан хувь хэмжээнд хоол хүнсний бүтээгдэхүүн болон эмчилгээний эмийн бүтээгдэхүүн хамаарна.

Ус, урлаг, ном, сонин, сэтгүүл, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан туслах багаж, хиймэл эрхтэн, газар тариалангийн зарим бараа, үйлчилгээ, зорчих тээвэр, спорт, хөдөлмөр шаардсан үйлчилгээ болон театр, жүжиг, музей, кинотеатр, спортын арга хэмжээ, хөгжөөнт тоглоомын парк, амьтны хүрээлэн, циркийн орох тасалбар зэрэг бараа үйлчилгээнд ногдуулах татварын хэмжээ харьцангуй бага байна.

Татвар төлөгч НӨАТ-ын мэдүүлгийн маягтыг заавал бөглөж өгнө. Татвар төлөгч нь НӨАТ-ын буцаан олголтоо сар бүр, улирал бүр, жил бүр авах эсэхээ өөрөө тогтоох боломжтой. Татварын удирдах газар мэдүүлгийг хүлээн авснаас хойш нэг сарын дотор буцаан олголтыг хянаж шийдвэрлэнэ. Татвар төлөгч нь мэдүүлгийн маягтыг хугацаанаас нь хоцроосон тохиолдолд торгууль ногдуулна.

¹¹⁵ ftnref1 Wet op de omzetbelasting 1968 - Wet OB.
http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013

3.3. ОХУ


3.3.1.НӨАТ-ын буцаан олголт

НӨАТ-ын эрх зүйн харилцааг ОХУ-ын Татварын тухай хуулийн (2000 он) 21 дүгээр бүлгээр¹¹⁶ зохицуулах бөгөөд уг татвар нь Холбооны татварт хамаарна. Татварын тухай хуулийн 145 дугаар зүйлд зааснаар ААН, хувь хүний өмнөх (дараалсан) 3 сарын хугацааны бараа (ажил, үйлчилгээ)-ны борлуулалтын дүн нь 2 сая рублээс хэтрээгүй бол жилийн хугацаанд чөлөөлөгдөнө.

НӨАТ-ын ерөнхий хувь хэмжээ нь 18 хувь бөгөөд эрүүл мэндийн болон хүүхдийн бүтээгдэхүүн, тогтмол хэвлэл, ном болон зарим хүнсний бараанд 10 хувиар ногдуулахаар Татварын тухай хуулийн 164 дүгээр зүйлд заасан байна.

НӨАТ-ын буцаан олгох журмыг ОХУ-ын татварын хуулийн 21 дүгээр бүлэгт тодорхойлсон. НӨАТ-ын тооцоолсон дүнгээс хэтэрсэн дүнг буцаан олгоно.

Зураг 3. НӨАТ-ыг буцаан олгох үйл явц



1) *Татвар төлөгч нь ХТА-нд татварын тайлангаа гаргаж өгөх:* Экспортод гаргасан барааны НӨАТ-ын буцаан олголтыг баталгаажуулж буцаан олгохын тулд дор дурдсан шаардлага тавина. Үүнд:

- тэдэнд экспортын орлого нь бараа хилээр гарснаас хойш 6 сарын дотор ОХУ-ын банкин дахь дансанд орсон байх,
- бараа солилцоогоор төлбөрийг авахаар тохиролцсон бол уг бараа нь ОХУ-ын нутаг дэвсгэрт орж ирсэн нь гаалийн байгууллагаар нотлогдсон байх,
- бэлэн мөнгө хүлээн авсан бол уг мөнгөө ОХУ-ын арилжааны банкин дахь дансанд төвлөрүүлсэн нь банкны тодорхойлолтоор нотлогдсон байх гэх мэт.

Мөн барааг экспортод гаргасан тухай гаалийн мэдүүлэг, экспортын барааны орлого дансанд төвлөрсөн тухай банкны тодорхойлолт, санхүүгийн тайланд тусгасан тэмдэглэл, татвар төлөгчийн өргөдөл, экспортын гэрээ зэрэг Татварын тухайн хуулийн 165 дугаар зүйлд заасан баримт бичгүүдийг хавсаргана.

2) *ХТА нь татварын тайланг хянах:* Холбооны татварын алба (ХТА) нь татвар төлөгчийн НӨАТ-ын тайланг Татварын тухай хуулийн 88 дугаар зүйлд заасан журмын дагуу тайлан ирсэн өдрөөс хойш 3 сарын хугацаанд хянаж үзнэ. Хянах явцад ХТА нь татвар төлөгчөөс татварын хасалт хийхэд хуульд заасан нотлох баримт бичгээс өөр нэмэлт мэдээлэл, баримт бичгийг шаардах эрхгүй.

3) *ХТА нь татварын шийдвэр гаргах:* Холбооны татварын алба (ХТА) нь татвар төлөгчийн НӨАТ-ын тайланг хянаж үзээд татварын тайланд мэдүүлсэн НӨАТ-ыг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн) буцаан олгох, эсхүл олгохгүй байх шийдвэрийг гаргана.

ХТА нь НӨАТ-ын буцаан олгох шийдвэр (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн)-ийг НӨАТ-ын дүнг буцаан олгох, эсхүл холбогдох шийдвэрийг гарснаас хойш 5 хоногийн дотор буцаан олгохоос татгалзсан шийдвэрийн талаар бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

4) *НӨАТ-ыг буцаан олгох:* Буцаан олголтын дүнг татварын хууль тогтоомжийн дагуу татварын өр төлбөр (албан татварын дутуу төлөлт, анз, торгууль)-ийг төлөх, ирээдүйд төлөгдөх татварт урьдчилж авах, эсхүл татвар төлөгчийн дансанд буцаан олгоно. Тайланг хянаж дууснаас хойш 3 сарын хугацаанд НӨАТ-ыг буцаан олгоно.

¹¹⁶ "Налоговый кодекс Российской Федерации (часть вторая)" от 05.08.2000 N 117-ФЗ (ред. от 07.03.2018), Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость. www.consultant.ru

3.3.2.НӨАТ-ын орлого ба тулгамдсан асуудлууд

НӨАТ-ын орлого нь түүхий эд, эрчим хүчний дэлхийн зах зээлийн үнэ цэнээс хамааралтай байдаг тул улсын санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангаж байдаг тул төсөвт ихээхэн үнэ цэнтэй байдаг бөгөөд энэ нь эдийн засгийн хямралын үед улам бүр мэдрэгдэж байдаг.¹¹⁷


НӨАТ нь ОХУ-ын Төсвийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу Холбооны төсөвт орох бөгөөд Холбооны 2015 онд төсвийн орлогын 35,6 хувийг бүрдүүлсэн томоохон эх үүсвэр болдог байна.

Хүснэгт 1. НӨАТ-ын орлогын хэмжээ, Холбооны төсөвт эзлэх хувь (2014-2015 он)¹¹⁸

	2014 он		2015 он	
	Дүн (тэрбум рубль)	Эзлэх хувь	Дүн (тэрбум рубль)	Эзлэх хувь
Нийт татварын орлого	6 214,60	100,0	6 880,50	100,0
Үүнээс: НӨАТ	2 181,40	35,1	2 448,30	35,6

Тус улсын Холбооны 2015 оны төсөвт НӨАТ-аас 2448,3 сая рубль орж ирсэн нь 2014 оныхтой харьцуулахад 11 хувь, харин 2010 оныхоос 46 хувиар, 2000 оныхоос 7 дахин өссөн байна. (Зураг 3.)

Зураг 4. НӨАТ-ын орлогын үзүүлэлт (2000-2015 он, тэрбум рубль)



Эдийн засгийн ухааны доктор М.В.Мишустины судалгаанаас үзэхэд НӨАТ-ын суурийн динамик нь инфляцийн түвшин, бодит худалдааны эргэлтээс хамаардаг. Мөн татварын дүнг тооцоолохдоо импортын, ам.долларын ханшийн өөрчлөлтөд нөлөөлдөг НӨАТ-ын хасалтыг харгалзан үзэх шаардлагатай.

Ам.долларын ханшийн өсөлт нь импортын бараа (үйлчилгээ)-ны өртөгт нөлөөлж үнийн өсөлтийг бүрдүүлж байна. Инфляц нь мөн үнийн өсөлтөөс хамаарч татварын суурийг нэмэгдүүлж байна. Үүнтэй зэрэгцэн иргэдийн худалдан авах чадвар буурч, үйлдвэрлэл, барааны хэмжээ багасаж байдаг.


Доорх зургаас үзэхэд, татварын орлогын гол өсөлт нь инфляцийн өсөлт (+158 тэрбум рубль), импортын бууралт (+76 тэрбум рубль)-аас гадна худалдааны эргэлт буурч, рублийн ханш суларсантай зэрэгцэн татварын хэмжээ буурсан зэргээс хамаарсан байна.

¹¹⁷ "Факторы роста налоговых доходов: макроэкономический подход". М.В.Мишустин (доктор экономических наук). Экономическая политика. 2016. Т. 11. No 5, стр. 8-27. <https://cyberleninka.ru/>

¹¹⁸ "Роль косвенных налогов в формировании доходов бюджета". Н.М.Турбина, А.Ю. Фёдорова. Социально-экономические явления и процессы, 2016, No 7, стр. 41-47. <https://cyberleninka.ru/>

Ийнхүү инфляц, худалдааны эргэлт, импортын өөрчлөлт, ам.долларын ханш зэрэг үзүүлэлтүүд өөрчлөгдснөөс хамаарч 2016 оны эхний хагас жилийн татварын орлого 22 тэрбум рублээр өссөн байна.

Зураг 5. НӨАТ-ын бүрдүүлэлтэд макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн нөлөөллийн дүн (2000-2015 он, тэрбум рубль)



Хэдийгээр Холбооны төвийн орлогод НӨАТ-аас бүрдүүлж орлогын хэмжээ тогтмол өсөж байгаа боловч дор дурдсан асуудлууд шийдвэрлэгдээгүй байна.¹¹⁹ Үүнд:

- Шууд бус татварууд нь дотоодын үйлдвэрлэлийн өсөлт, үндсэн хөрөнгийн хөрөнгө оруулалтыг саатуулж байна. Үүнийг хөрөнгө оруулалтыг дэмжихийн тулд татварын хууль тогтоомжид өөрчлөх;
- НӨАТ-аас үүдэн инфляц тогтмол өсөж байна. Энэ асуудлыг шийдэхийн тулд НӨАТ-ын үндсэн хувь хэмжээг бууруулах, татварын хөнгөлөлтүүдийг багасгах;
- Экспортын барааны НӨАТ-ын буцаан олголтыг хууль бусаар олгож байна. Үүний тулд татварын зарим хөнгөлөлтүүдийг цуцлах;
- НӨАТ-ыг бүрдүүлэлт, ялангуяа НӨАТ-ын тооцоолол болон буцаан олголтод учирч байгаа хүндрэлүүд нь Оросын ААН, компаниудыг олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулахад саад болж байна.

¹¹⁹ “Роль косвенных налогов в формировании доходов бюджета”. Н.М.Турбина, А.Ю. Фёдорова. Социально-экономические явления и процессы, 2016, No 7, стр. 41-47. <https://cyberleninka.ru/>

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- ftnref1 Wet op de omzetbelasting 1968 - Wet OB. Эх сурвалж: http://wetten.overheid.nl/BWBR0002629/geldigheidsdatum_04-07-2013
- Налоговый кодекс Российской Федерации (НК РФ), Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость
- The SII Commissioner Julio Pereira, 2011, 2010 Official Accounts address, Santiago
- "Налоговый кодекс Российской Федерации (часть вторая)" от 05.08.2000 N 117-ФЗ (ред. от 07.03.2018), Раздел VIII. Федеральные налоги, Глава 21. Налог на добавленную стоимость. www.consultant.ru
- "Факторы роста налоговых доходов: макроэкономический подход". М.В.Мишустин (доктор экономических наук). Экономическая политика. 2016. Т. 11. No 5.
- "Роль косвенных налогов в формировании доходов бюджета". Н.М.Турбина, А.Ю. Фёдорова. Социально-экономические явления и процессы, 2016, No 7.
- <http://www.government.nl/issues/taxation>
- www.chinatax.gov.cn
- <http://tax.mofcom.gov.cn/tax/taxfront/en/list.jsp>
- www.ibfd.org/sites/ibfd.org/files/content/pdf/ivm_2017_02_cn_1_PPV_AugNewsletter.pdf
- <http://world.salestaxhandbook.com/cn-china/vat-refund>
- <https://assets.kpmg.com/content/dam/kpmg/pdf/2016/03/china-tax-alert-09-vat-implementation-rules.pdf>
- European VAT refund guide 2017.
- www2.deloitte.com/global/en/pages/tax/articles/vat-refund-guide.htm
- www.vatlive.com/country-guides/europe/finland/finnish-vat-rates/
- Value added tax act. www.finlex.fi/en/laki/kaannokset/1993/en19931501.pdf
- Тайвань өнөөдөр цахим хуудас <https://taiwantoday.tw/news.php?unit=6,23,6&post=12463>
- 2015 оны албан татвар судалгаанаас <https://home.kpmg.com/content/dam/kpmg/pdf/2015/10/taiwan-2015.pdf>
- БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас <http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll.aspx?PCode=G0340080>
- Сангийн яамны е- татварын цахим хуудас https://www.etax.nat.gov.tw/etwen/Value_sub_in04.html
- <http://admin.taiwan.net.tw/upload/law/20150907/3db03f8f-b961-4da1-8fc5-fd71579321a.pdf>
- БНХАУ-ын хууль, дүрэм журмын цахим хуудас http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll_print.aspx?PCode=G0340126
- Сангийн яамны цахим хуудас
- <http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=75>
- СЯамны цахим хуудас <http://law-out.mof.gov.tw/EngLawContent.aspx?Type=E&id=250>
- "НӨАТ төлөгч болон НӨАТ төлөгч бус бизнесийн хууль"-ийн 3-р бүлгийн 10-13 зүйл <http://law.moj.gov.tw/eng/LawClass/LawAll.aspx?PCode=G0340080>
- Сангийн яам <https://www.mof.gov.tw/Eng/Detail/Index?nodeid=319&pid=71590>
- "The VAT: Its Causes and Consequences". M.Keen and B.Lockwood. International Monetary Fund. 2017.
- How Many Countries in the World Have a Value-Added Tax. Kyle Pomerleau. <https://taxfoundation.org>
- Stefan Gabriel ets. "The influence of VAT on economic growth". 2015.
- www.ibfd.org/sites/ibfd.org/files/content/pdf/ivm_2017_02_cn_1_PPV_AugNewsletter.pdf
- "Нэмэгдсэн өртөгийн албан татварын буцаан олголт, гадаадын зарим орны туршлага". УИХ-ын Тамгын газрын Судалгаа, шинжилгээний хэлтэс. 2013 он.
- Борлуулалтын татвар ба НӨАТ-ын харьцуулсан судалгаа, О.Цогт
- НӨАТ ба хэрэглээний татварын хувилбарууд. Р.Кревер. www.iltod.gov.mn